Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	127,149,675.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	127,149,675.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	127,149,675.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	127,149,675.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	127,149,675.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	127,149,675.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	127,149,675.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	124,174,420.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,687,663.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,287,592.00
131106	Хаагдсан данс	0.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ сумын засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төр засгийн бодлого шийдвэрийг сурталчлах, таниулах замаар төрийн үйлчилгээг жигд хүргэх, төр нийгмийн ажилд иргэдийг өргөнөөр оролцуулах, тэдний үйл ажиллагааг идэвхжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Мөн сумын төсөвт байгууллагуудын төсвийн орлого зарлага зарцуулалтын үйл ажиллагаа төрийн болон орон нутгийн өмчийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих удирдлагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх бодит мэдээ мэдээллээр хангах зорилго тавин ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын засаг захиргаа түүний удирдлагын нэгжийн тухай хууль.төсвийн тухай хууль төрийн албаны тухай хууль нягтлан бодох бүртгэлийн тухай хууль.аудитын, төрийн хяналт шалгалтын хууль болон эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13.8 сая төгрөгөөр буюу 100 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	351.3	213.6	-137.7
Авлага	243.5	259.6	16.0
Бараа материал	88.3	83.5	-4.7
Үндсэн хөрөнгө	975.7	1,116.0	140.3
Нийт хөрөнгө	1,658.9	1,672.8	140.3
Өр төлбөр	5.6	9.7	4.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,653.3	1,663.0	9.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,658.9	1,672.8	13.8

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс ХХС-гийн зээлийн авлага авлага 16.0, үндсэн хөрөнгө 140.3 сая төгрөгөөр өссөн нь зээл нэмэгдэж гарсан, ОНХС-гийн хөрөнгөөр болон хандиваар хөрөнгө нэмж олгосонтой холбон үзэж байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 213.6 сая төгрөг болж, өмнөх оноос 137.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө			
Төгрөг			
Төрийн сангийн харилцах	351.4	213.6	-137.6
Арилжааны банк дахь харилцах			
Гадаад валют			
Арилжааны банк дахь харилцах			
Замд яваа мөнгөн хөрөнгө			
Дүн	351.4	213.6	-137.6

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс үзэхэд ОНХС-гийн дансанд 59.7, ерөнхий орлогын дансанд 72.0, ХХС-гийн дансанд 8.5, БХС-гийн дансанд 55.7, ЖДҮДС-гийн дансанд 17.4, “Ингэт дөл” ОНӨААТҮГ-гийн дансанд 0.3 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

Аудитын илрүүлэлт

БХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг 0.2, томилолтын зардлыг 0.2, шатахууны зардлыг 0.2 сая төгрөгөөр илүү, ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний ажил хийгдээгүй байхад 6.0 сая төгрөгийг шилжүүлсэн, батлагдаагүй төсөл арга хэмжээний ажилд 0.3 сая төгрөгийг зарцуулсан, гэрээний хугацаанд хийгдээгүй ажил 0.2 сая төгрөгийн алданги тооцоогүй зөрчилд нийт 7.1 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоосон.

БХС-гийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг үнэн зөв, бодит тайлагнах зарчим алдагдсан, төсвийн хэлбэлзлээр зарцуулах эрхийг 334.9, мөнгөн гүйлгээний тайлангаар мөнгөн орлогыг 299.6 сая төгрөгөөр буюу 35.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 259.6 сая төгрөг болж, өмнөх оноос 16.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага		0.8	0.8
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Дансны авлага /ТӨҮГ/			
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	0.001	0.001	0
Татаас, санхүүжилтийн авлага			
Байгууллагаас авах авлага	9.4	9.4	0
Хувь хүмүүсээс авах авлага	234.1	249.4	15.3
Дүн	243.5	259.6	16.1

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар ХХС-гийн авлага 245.6, ЖДҮДС-гийн авлага 3.8, НД-аас авах шимтгэлийн авлага 0.8, ерөнхий орлогын дансанд 9.4 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт

Алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансанд үлдэгдэлгүй болно.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал			
Урьдчилгаа тооцоо			

Бараа материал бэлтгэх урьдчилгаа			
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа			
Дүн			

Эх сурвалж:

Аудитын илрүүлэлт:

Алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 83.5 сая төгрөг болж, өмнөх оноос 4.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал			
Тусгай зориулалттай материал			
Эм боох материал			
Дуусаагүй үйлдвэрлэл			
Бэлэн бүтээгдэхүүн			
Хангамжийн материал	80.4	81.6	0.1
Бичиг хэргийн материал	0.1	0.1	
Аж ахуйн материал	38.1	33.4	-4.7
Сэлбэг хэрэгсэл	4.0	4.0	0
Түлш, шатах тослох материал			
Барилгын засварын материал			
Хүнсний материал			
Бусад хангамжийн материал	38.1	44.1	5.9
Мал амьтад	7.8	1.8	-6.0
Дүн	88.3	83.5	-4.7

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс үзэхэд бараа материалын үлдэгдэл буурсан нь материал акталж устгасантай холбон үзэж байна.

Аудитын илрүүлэлт

БХС-гийн хөрөнгөөр “Зэд хантай бүтээлийн нуруу-Дархан цаазат газрын захиргаа”-нд 10 тооны морьдыг 10.0 сая төгрөгөөр худалдан авч өгсөн боловч тус газар нь орлого авч тайлан бүртгэлд тайлагнаагүй зөрчилд албан шаардлага бичсэн.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн данс үлдэгдэлгүй болно.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад			
Дүн			

Эх сурвалж:

Аудитын илрүүлэлт

Алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,116.0 сая төгрөг болж, өмнөх оноос 140.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	959.9	912.9	-47.0
Барилга, байгууламж, орон сууц	358.9	341.8	-17.1
Авто-тээврийн хэрэгсэл	228.2	224.6	-3.6
Машин тоног төхөөрөмж(компьютер)	167.5	137.0	-30.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	10.4	14.8	4.4
Бусад үндсэн хөрөнгө	194.9	194.7	-0.2
Дуусаагүй барилга, байгууламж			
Биет бус хөрөнгө	15.8	203.1	187.3
Программ хангамж	2.0	3.9	1.9
Бусад биет бус хөрөнгө	13.7	199.1	185.4
Бусад хөрөнгө /ТӨҮГ/			
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/			
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + Бусад			
Дүн	975.7	1,116.0	140.3

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс үзэхэд үндсэн хөрөнгө 140.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь сумын ЗДТГ-ын эзэмшлийн газар орлогод авснаар үндсэн хөрөнгө 185.4 сая төгрөгөөр нэмэгдэж, барилга байгууламж 11.4, машин тоног төхөөрөмж 27.4, тавилга эд хогшил 2.2 сая төгрөгөөр тус тус хасагдсантай холбон үзэж байна.

Аудитын илрүүлэлт:

БХС-гийн хөрөнгөөр баригдсан 20.0 сая төгрөгийн “Харцайн ам”-ны харуулын барилгыг орлогод аваагүй, сумын ЗДТГ нь ашиглаж байгаа үндсэн хөрөнгүүдийг кодлоогүй зэрэг алдааг аудитын явцад залруулсан.

БХС-гийн 2.2 сая төгрөгөөр баригдсан “Эко 00”-ийг “Зэд хантайн бүтээлийн нуруу-Дархан цаазат” газрын захиргаа нь орлогод аваагүй зөрчилд албан шаардлага өгч ажиллалаа.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 9.6 сая төгрөг болж, өмнөх оноос 4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	1.5	3.8	2.3
Татварын өглөг	4.1	5.8	1.7
НДШ-ийн өглөг		0.001	0.001
Дүн	5.6	9.6	4.0

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр өмнөх оноос 4.0 сая төгрөгөөр өссөн нь "Ингэт дөл" ОНӨААТҮГ нь ажилчдын цалинг 2.3, ХХОАТ-ыг 1.7 сая төгрөгөөр тус тус нэмж тайлагнасангай холбон үзэж байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар зөрчил илрээгүй.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,663.0 сая төгрөг болж өмнөх оноос 9.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	465.3	650.7	185.5
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	347.5	347.5	0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			
Хуримтлагдсан үр дүн	442.5	270.0	-172.4
Өмнөх үеийн үр дүн	4,558.3	445.8	-4,112.5
Тайлант үеийн үр дүн	4,115.9	-175.8	-3,940.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	398.0	394.8	-3.1
Дүн	1,653.3	1,663.0	9.7

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо нэмэгдсэн нь биет бус хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагын нийт зардлыг 2,065.4, сумын орлогыг 464.0, санхүүгийн дэмжлэг 940.7, сумын ОНХС-гаас 256.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн XIV/01 дүгээр тогтоолоор төсөвт тодотгол хийж төсвийн төслийн саналаас нийт зардлыг 317.4, сумын орлогыг 36.3 сая төгрөгөөр тус тус нэмж баталсан байна.

Энэ нь цалингийн зардал нэмэгдсэнтэй холбон үзэж байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,639.4, ОНХС-гаас 323.5, үндсэн үйл ажиллагааны орлогоос 69.2, өмнөх оны үлдэгдлээс 350.6 сая төгрөг буюу нийт 2,382.8 сая төгрөгөөр зардлыг, сумын татварын болон татварын бус орлогыг 500.3 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,755.4, ОНХС-гаас 321.1, үндсэн үйл ажиллагааны орлогоос 45.1 сая төгрөг буюу нийт 2,121.7 сая төгрөгийн санхүүжилт авч ажилласан байна.

Сумын татварын болон татварын бус орлогыг 488.0 сая төгрөг буюу 97.5 хувиар бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,092.7 сая төгрөг буюу 93.3 хувиар илэрхийлэгдэж байна.

Цэвэр мөнгөн гүйлгээний тайлангаар 213.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь ОНХС-гийн дансанд 59.2, ХХС-гийн дансанд 8.5, БХС-гийн дансанд 55.7, ЖДҮДС-гийн дансанд 17.4, ерөнхий орлогын дансанд тогтмол зардлын 72.0, “Ингэт дөл” ОНӨААТҮГ-ийн дансанд 0.3 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ЗДТГ 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	610.7	542.9	67.8	89
2	ЗДТГ 80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	101.5	95.5	6	94
3	ЗДТГ 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	30.0	30.0	0	100
4	ЗДТГ 82801 Улсын их баяр наадам	5.0	5.0	0	100
5	ЗДТГ 82212 Хог хаягдал орчны бохирдол	5.0	5.0	0	100
6	ЗДТГ 80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн	13.7	13.7	0	100
7	ЗДТГ 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	26.8	26.8	0	100

/сая төгрөгөөр/

8	ИТХ 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	96.1	95.5	0.6	99
9	ИТХ 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	2.3	2.3	0	100
10	ИТХ 80825 Багийн ИНХ-ын даргын урамшуулал	6.7	4.4	2.3	65
11	ИТХ 82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	2.0	2.0	0	100
12	ЕБС 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	378.8	378.8	0	100
13	СӨБ 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	71.6	71.6	0	100
14	ЭМТ 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	60.1	56.6	0	94
15	Соёл 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	110.1	110.1	0	100
16	ОНХСан Итгэлцүүрээр олгох, Малын тоо толгойн албан татвар	420.2	313.3	106.9	74
17	ХХСан Дотоод эх үүсвэрээр олгох зээл	86.0	54.5	31.5	63
18	БХСан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	334.9	281.7	53.2	84
19	ЖДҮДСАН Дотоодын эх үүсвэрээр олгох зээл	21.3	3.0	18.3	14
Нийт дүн		2382.8	2092.7	290.1	88

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ЗДНХ-өөс 108.6, авто замын сангаас 15.0, статистикийн хэлтсээс 1.4, иргэнээс 1.3, аймгийн ИТХ-аас 0.3 сая төгрөг буюу нийт 127.1 сая төгрөгийн санхүүжилтийг нэмэлт дансаар авч гүйцэтгэлээр цамхагт худгийн зарцуулалтад 105.2, хог цэвэрлэгээнд 1.8, алсын хараа 2050 сургалтад 2.2, зам засварын ажилд 15.0, малын тооны шатахуунд 1.4, түймрийн хоол хүнсний зардалд 1.3, сургалт сурталчилгаанд 0.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус онд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй болно.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/89 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүү үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн зарлагын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүү үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн зарлагын 3,133.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 46.7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтээр 10 горим, сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн ч тус сумын ИТХ болон ОНХС-гийн хөрөнгөөр нийт 18.8 сая төгрөгөөр машин тоног төхөөрөмж худалдан авч бэлтгэсэн нь тус хуулийн 14 дүгээр зүйлийн 4-т “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно.” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй цахим дэлгүүрээс худалдан авалтыг хийгээгүй байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд шилэн дансанд 144 мэдээлэл тайлагнахаас мэдээллийг бүрэн тайлагнаж ажилласнаас төсөв гүйцэтгэлтэй холбоотой дараа сарын 8-ны дотор мэдээлэх батлагдсан төсөв гүйцэтгэл, тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, ОНХС-гийн төлөвлөгөө гүйцэтгэлийн 1 болон 9 дүгээр саруудад мэдээлэх 5 мэдээг хугацаа хороож мэдээлсэн зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж хүргүүлсэн.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сэлэнгэ сум нь 2023 онд 21 нэр төрлийн татварын болон татварын бус орлогоос 500.3 сая төгрөгийн орлогыг төлөвлөж гүйцэтгэлээр 488.0 сая төгрөг буюу 97.5 хувиар орлого бүрдүүлжээ.

Тус сумын БХС-гийн санхүүгийн тайланг төсвийн хэлбэлзлийн дүн, дансны хуулгаар тулгахад 35.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Хуулгаар 5 дансны гүйлгээ хийсэн тулгахад 99639.5 мянган төгрөгийн 34 алдаатай гүйлгээ хийсэн, 833.9 мянган төгрөгөөр орлого, зардлыг нэмэгдүүлж, үнэн зөв, бодит тайлагнах зарчим алдагдсан, ЖДҮДС-гийн 3.7 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, “Зэд хантай бүтээлийн нуруу-Дархан цаазат газрын захиргаа”-ны гэрээний хэрэгжилтийг дүгнэж 4.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоор сумын ИТХ-аар батлуулан БХС-гийн орлогоос олгосон боловч хэрэгжилтийн тайлан болон АШБ-ийн бүрдэлт дутуу, гэрээнд тавих хяналт сул зэрэг зөрчлүүд илэрсэн.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж хүргүүлсэн.

Мөн БХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 2.2 сая төгрөгийн “Эко-00”, 10 тооны 10.0 сая төгрөгийн морьдыг орлогод авч бүргээгүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*”, 13 дугаар зүйлийн 6-д “*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.*” 13 дугаар зүйлийн 7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.*”, 14 дүгээр зүйлийн 4-т “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:*” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлсэн.

Сумын ОНХС-гийн хог цэвэрлэгээнд 15.0 сая төгрөг баталсан боловч гүйцэтгэлээр 15.2 сая төгрөг зарцуулж, 0.2 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” сумын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн ИТХ-ын 14/01 тоот тогтоол болон бусад хуулийн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоосон.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хийсэн ажил, үр дүнгийн талаар товч бичнэ. Хэрвээ асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн бол биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үр дүнг аудитын тайланд тусгана. Биелэлт хангалтгүй бол тайлант оны буруу илэрхийллийн дүнд оруулна.

Завсрын аудитаар тус сумын ЗДТГ, ИТХ-ын 2023 оны эхний хагас жилийн байдлаарх үйл ажиллагааг хамруулж шалгасан.

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг асуудлын бүртгэлээр баталгаажуулж үндсэн хөрөнгийг кодолж ажиллаагүй зөрчлийг жилийн эцэст залруулж тайланг авч ажилласан.

Биет тооллогоор дутагдсан 6.5, томилолтын зардлыг 0.2, шатахууны зардлыг 0.2 сая төгрөгийг тус тус илүү, төсөв батлаагүй төсөл арга хэмжээний ажилд 0.3 сая төгрөг зарцуулсан зөрчлүүдийг жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитын асуудлын бүртгэлд нэгтгэж баталгаажуулан ажилласан.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/130 тоот албан бичгээр тайлан болон нотлох баримтыг ирүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	387.5	2	387.5	100
Албан шаардлага					
Зөвлөмж	4	0	4	0	100

Нийт дүн	6	387.5	6	387.5	100
----------	---	-------	---	-------	-----

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумын ерөнхий орлогын дансанд 9.4, ХХС-гийн санхүүгийн тайланд авлагаар тусгасан 9.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлүүд нь олон жил болсон эзэн нь тодорхойгүй байгааг цаашид анх ямар шалтгаанаар үүссэнийг тодорхойлж данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 71.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 20.0 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 0.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 12.2 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 39.1 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Үүнд: ОНХС-гийн хөрөнгөөр баригдсан 20.0 сая төгрөгийн барилга байгууламжийг үндсэн хөрөнгийн дансанд орлого авч тайлагнаагүй алдааг НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-т " *Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна.*" гэсэн заалтыг үндэслэн залруулж ажиллалаа.

Аудитаар нийт 51.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 0.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 12.2 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 39.1 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

БХС-гийн хөрөнгөөр хийгдэх "Хог цэвэрлэгээ"-ний ажилд 15.0 сая төгрөгийг баталсан боловч гүйцэтгэлээр 15.2 сая төгрөгийг зарцуулж 0.2 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-т "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*", 13 дугаар зүйлийн 6-д "*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.*" сумын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн ИТХ-ын 14/01 тоот тогтоол болон бусад хуулийн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-т "*бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн.*" гэж заасныг тус тус үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

5.2.1 Албан шаардлага

Эд хантай бүтээлийн нуруу-Дархан цаазат газрын захиргаанд 10 тооны морьдыг 10.0 сая төгрөгөөр БХС-гийн хөрөнгөөс худалдан авч өгсөн боловч тус газар нь санхүүгийн тайлан бүртгэлд орлого авч тайлагнаагүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*", 13

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 14 дүгээр зүйлийн 4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй.” гэж заасныг тус тус үндэслэн албан шаардлага бичлээ.

5.2.2 Албан шаардлага

Зэд хантай бүтээлийн нуруу-Дархан цаазат газрын захиргаа нь БХС-гийн 2.2 сая төгрөгийн хөрөнгөөр баригдсан “Эко 00”-ыг орлого авч санхүүгийн тайланд тайлагнаагүй, хэрэгжилтийн тайланг цаг хугацаанд хүлээлгэн өгч ажиллаагүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 14 дүгээр зүйлийн 4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй.” гэж заасныг тус тус үндэслэн албан шаардлага бичлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

ЖДҮДС-гийн зээлийн авлагын үлдэгдлийг зээлдэгч нартай жилийн эцэст тооцоо нийлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж зээлдэгч нартай хагас бүтэн жилээр тооцоо нийлж ажиллах.

2. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

БХС-гийн санхүүгийн тайланг тайлагнахдаа төсвийн хэлбэлзлээр тайлагнаагүй, 35.3 сая төгрөгөөр зөрүүтэй, дансны хуулгаар 5 дансаар гүйлгээ хийсэн боловч 99.6

сая төгрөгийн 34 алдаатай гүйлгээ хийсэн, 833.9 мянган төгрөгөөр орлого, зардлыг нэмэгдүүлж тайлагнасан байна.

Өгсөн зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална.” гэсэн заалтыг мөрдлөгө болгож хяналтыг сайжруулан алдаатай гүйлгээ хийхгүй байхаар ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТТЗ	1	20.0	1	20.0								
ОНХС	1	15.0	1	15.0								
Дүн	2	35.0	2	35.0								

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	5	51.5	1	0.2	2	12.2	2	39.1				
ЗДТГ	2	6.7	2	6.7								
ИТХ	1	0.2	1	0.2								
ОНХС	3	6.5	3	6.5								
Дүн	11	64.9	7	13.6	2	12.2	2	39.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								

Дүн								
Нийт дүн	1	0					1	0